

8.3. Баталгаажуулах хүсэлт

8.3 Баталгаажуулах хүсэлт

Сургууль дээр шинэ суралцагч бүртгэх үед тухайн суралцагчийн анги, боловсролын түвшин болон хөтөлбөр зөрүүтэй үед аймаг, нийслэлийн БСУГ -ын холбогдох мэргэжилтнээр заавал баталгаажилт хийлгэх шаардлагатай. Аймаг, нийслэлийн түвшинд хүсэлтийг хүлээн авч суралцагчийн мэдээллийг баталсан тохиолдолд БСШУСЯ -нд илгээнэ. Боловсролын удирдлага системийн **Суралцагч** модульд суралцагчийг нэмэх үед **Хянагдаж байгаа** төлөвтэйгээр суралцагч бүртгэгддэг.

Хянагдаж байгаа төлөвтэй суралцагчийн баталгаажуулах хүсэлтийн явцыг **Баталгаажуулах хүсэлт** модулиар шалгана.

Сургуулиас харьяалагдах Аймаг, нийслэлийн боловсрол газарт илгээсэн суралцагчийн бүртгэлтэй холбоотой баталгаажуулах хүсэлтүүд аль түвшинд ямар явцтай байгааг энэ цонхноос харах боломжтой.

Баталгаажуулах хүсэлт

Хайх...

1 2020-21 Хичээлийн жил

2 Хүсэлтийн төрөл

- ☒ Шинэ суралцагч нэмсэн
- ☒ Хөтөлбөр хооронд шилжсэн
- ☒ Экстранат

3 Хүсэлтийн төлөв

- ☒ Хянагдаж байгаа
- ☐ Батлагдсан
- ☐ Цуцлагдсан

№	Нэр	Регистр	Хүсэлтийн төрөл	Бүлэг	Баталгаажуулах түвшин	Огноо	Төлөв
1	Б.Ирмүүн-Оюу		Шинэ суралцагч нэмсэн	106 (2...	БСШУСЯ	2020-08-28	Хянагдаж байгаа
2	Б.Ундрам		Шинэ суралцагч нэмсэн	ба (20...	БСШУСЯ	2020-08-27	Хянагдаж байгаа

4

5

Хүсэлт илгээсэн: Улаанбаатар.Хан-Уул.Орхон ахлах сургууль ()

Суралцагч: Б.Ирмүүн-Оюу

Хөтөлбөр: Бүрэн дунд хөтөлбөр /ЕБС - Олон улсын СІЕ хөтөлбөр/

Тайлбар: Нэмэлт тайлбарыг бичнэ...

Бүлэг: 106 (2020-2021)

6

Баталгаажуулалтын явц

№	Нийслэлийн боловсролын газар	Батлагдсан	Огноо
1	Нийслэлийн боловсролын газар	Батлагдсан	2020-08-28
2	БСШУСЯ	Хянагдаж байгаа	2020-08-28

Хавсралт баримт бичиг

№	Төрөл	Файлын нэр	Файлын хэмжээ
1	Эцэг эхийн өрг...	өргөдөл 1.pdf	27168.78 mb
2	Эцэг эхийн өрг...	өргөдөл 2.pdf	2712.143 kb
3	Сургуулийн тод...		
4	Аймаг БСУГ, Н...		
5	БШУЯ тодорхой...	irmuun-oyu yam bichig.pdf	488.546 kb

Суралцсан түүх

Огноо	Сургууль	Хөтөлбөр	Бүлэг	Үйлдэл	Шалтгаан	Баталгаажуулалт
2020-08-20	Улаанбаатар.Хан-Уул.Орхон ахлах сургууль	Бүрэн дунд хөтөлбөр /ЕБС - Олон улсын СІЕ хөтөлбөр/	106 (2...	Шинэ суралцагч	Сургууль завс...	Хянагдаж байгаа
2020-04-15	Улаанбаатар.Хан-Уул.Орхон ахлах сургууль	Суурь боловсролын өдрийн хөтөлбөр /Ердийн/	9-Б	Хасах	Бусад улс руу ...	Батлагдсан

1. **Хичээлийн жил** -ийг энэ хэсгээс сонгоно. Өмнөх хичээлийн жилийн мэдээллийг түүх байдлаар харах боломжтой.

2. **Хүсэлтийн төрөл** хэсгээс “Шинэ суралцагч нэмсэн”, “Хөтөлбөр хооронд шилжсэн”, “Экстранат” төрлүүдээр шүүлт хийж болно.

3. **Хүсэлтийн төлөв** хэсгээс “Хянагдаж байгаа”, “Батлагдсан”, “Цуцлагдсан” сонголтууд хийж 5-р хэсгийн жагсаалтыг өөрчилж болно.

4. **Хайлт** хэсэгт суралцагчийн нэр эсвэл регистрийн дугаарыг оруулж баталгаажуулах хүсэлтийн жагсаалтаас хайлт хийх боломжтой.

5. Баталгаажуулах хүсэлтийн **жагсаалт**

6. Тухайн сонгогдсон баталгаажуулах хүсэлтийн **дэлгэрэнгүй мэдээлэл**

- Хүсэлт илгээсэн сургууль
- Суралцагчийн мэдээлэл
- Хөтөлбөр төлөвлөгөөний мэдээлэл
- Баталгаажуулалтын явц – Аль түвшинд ямар явцтай байгааг харуулна.
- Хавсаргах баримт бичиг - Шаардлагатай бичиг баримтыг уг хэсэгт хавсаргах
- Суралцагчийн суралцсан түүх